

УЛСЫН ӨНДӨР СОЁЛЖИЛТТОЙ ХУЛД СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ



Тус сумын эрүүл мэндийн төв нь 20 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Манай байгууллага Их эмч 5, бага эмч-4, сувилагч-3 туслах ажилтан 9 нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй болж хүний нөөцийн хувьд батлагдсан орон тооны 95.4%-д хүргэсэн.

Сүүлийн хагас жилд буюу 6 сарын 14-нөөс хойш коронавирусын тархалт ихсэж нийт 370 хүн оношлогдож эмчлэгдсэн байна. Үүнд: жирэмсэн эх 8, хүүхэд /16 доош/ 81, хорт хавдараар өвчилсөн иргэн- 4, чихрийн шижин өвчтэй 6, 60-аас дээш настай ахмад 45 хүн хэвтэн эмчлүүлж нийт эдгэрсэн 365, одоо эмчлэгдэж байгаа 4, аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжин эмчлүүлсэн-10, өвчин нь хүндэрч дараагийн шатны эмнэлэгт шилжсэн-4, жирэмсэн шилжсэн-7, нас барсан -1 байна.

2021 онд тус ЭМТ-д ирсэн хандив тусламж

Сумын эрүүл мэндийн төвд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, коронавируст халдвараар өвчилсөн иргэдийн эмчилгээ сувилгаанд зориулж сайн

санаат иргэд аж ахуйн нэгж байгууллагууд хандив тусламж үзүүлсэн. Эдгээр байгууллага иргэдэд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа сумын нийт иргэдийн өмнөөс илэрхийлье.

- ▶ Улсын төсвөөр 1,5 тэрбум төгрөгөөр эмнэлэгийн шинэ барилга баригдаж ашиглалтад орлоо.
- ▶ 5 дугаар сард М.Эрдэнэбазарын үр хүүхдүүдээс 450,000 төгрөгийн үнэ бүхий хүчилтөрөгчийн баллон /10л/, эмнэлэгийн ажилчдад 400,000 төгрөгийн үнэ бүхий дархлаа сайжруулах амин дэм хандивласан байна.
- ▶ 6 дугаар сард тусгаарлах эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдээс 550,000 төгрөгийг хандиваар өгсөн
- ▶ Сумын Үйлдвэрчний Эвлэлийн Хорооноос 200,000 төгрөг хандивласан
- ▶ 7 дугаар сард Хулд сумын Нутгийн Зөвлөлөөс 6841,000 төгрөгийн үнэ бүхий Хүчилтөрөгч өтгөрүүлэгч 2ш, хамгаалах хувцас хэрэгсэл, амин дэм хандивласан
- ▶ Хулд сумын ЕБС-ийн 2-р төгсөлтийн Д.Эрдэнэтуяа даргатай хамт олноос сахиурын ор, утлагын аппарат өгсөн
- ▶ Улсын аварга малчин Х.Дэмбээ агсны үр хүүхдүүдээс тус эмнэлэгт цахилгаан мотор, настаны тэргэнцэр зэрэг 2 сая гаруй төгрөгийн эд зүйлс өгсөн
- ▶ 9 дүгээр сард нутгийн уугуул Довдонгийн Өлзийсайханы гэр бүлээс принтер-2ш, соруулагч аппарат 1, нийт 1,8 сая төгрөгийн эд зүйлсийг хандивласан.
- ▶ 10 сард Гөлтгөнө олборлогч “Эрдэнэгипс” ХХК-аас Хүчилтөрөгч өтгөрүүлэгч хандивласан
- ▶ Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 18,0 сая төгрөгийн хөрөнгөөр Биохимийн аппарат авч өгсөн.
- ▶ Хулд сумын уугуул Сумын ЭМТ-д ажиллаж байсан өндөр настан Л.Чагцал сумын ЭМТ-д 200,000 төгрөгийн үнэ бүхий хамгаалах хэрэгсэл хандивласан
- ▶ Тус сумын уугуул Бямбадоржийн Батбаяр, Тогоогийн Энхбат нараас 3 сая төгрөгийн үнэ бүхий 200 ширхэг оношлуур хандивласан
- ▶ Нутгийн уугуул Шантайн Болдбаатарын гэр бүлээс 600,000 төгрөгийн үнэ бүхий 30 ширхэг хамгаалах хувцас хандивласан байна.



Довдонгийн Өлзийсайханы гэр бүлээс



Улсын аварга малчин Х.Дэмбээ агсны үр хүүхдүүдээс

СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМНЭЛЭГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД 2021 ОНД ГАРСАН АХИЦ ДЭВШИЛ



Улсын төсвөөр 1,5 тэрбум төгрөгөөр эмнэлэгийн 2 давхар шинэ барилга баригдаж ашиглалтад орсноор хуучин эмнэлэгийн барилгаа халдвартын эмнэлэг болгон ашиглаж халдвар авсан бүх иргэдээ хэвтүүлэн эмчиллээ.



бууруулсан.

Сумын Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн авто машиныг тоноглон 12 вольтоос 220 вольт болгож гаргах өсгөгч суурилуулж хүчилтөрөгч өтгөрүүлэгч БОЛОН зөөврийн ЭХО аппарат ашиглан малчны хотонд ч оношлогоо эмчилгээ хийж эхэлснээс гадна хүнд өвчтөнийг тээвэрлэн хүргэх явцад гарах хүндрэл, эрсдлийг



Цусны биохимийн аппаратыг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 18,0 сая төгрөгийн хөрөнгөөр авч өгсөн нь нутгийн иргэдэд элэгний үйл ажиллагаа болон үе мөч, бөөрний нарийн шинжилгээг орон нутагтаа хийж оношлох нөхцөл болоцоог бүрдүүлсэн.

Сумын Эрүүл мэндийн төв нь хүний нөөц, тоног төхөөрөмжийн хувьд бэхжиж иргэддээ үйлчлэх бүрэн боломж бүрдлээ

Байгууллагын лого:



БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА:

Сумын эмнэлэгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт, Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан өндөр мэдлэг чадвар бүхий эмч мэргэжилтнүүдийн чадвараар ард иргэдийн хүсэн хүлээж буй эрэлт хэрэгцээнд нийцсэн, үр дүнд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг Эх, хүүхдэд ээлтэй эмнэлэгийн болзол хангасан загвар Эрүүл мэндийн төв болно.

БАЙГУУЛЛАГЫН ЭРХЭМ ЗОРИЛГО:

Эмч эмнэлэгийн мэргэжилтний ёс зүйг дээдлэн өргөсөн тангарагтаа үнэнч байж, иргэд үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээх нь бидний эрхэм зорилго